

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД МОНГОЛ УЛС-АНУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ АЧ ХОЛБОГДОЛ

*М.Хурметхан**

XXI зуунд Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн зорилтыг хангах бүс нутаг, дэлхийн эдийн засгийн интеграцид өөрийн гэсэн байр суурь, дуу хоолойтой байж, эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бэхжүүлэхэд эдийн засгийн харилцаа, түүний дотор гадаадын шууд хөрөнгө оруулалт чухал үүрэгтэй юм. Иймд, хөрөнгө оруулалтыг Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, үндэсний эрх ашигт нийцүүлэн ашиглах нь нэн тэргүүний зорилт болж байгаа юм. Аливаа орны аюулгүй байдалд бие биенээ нөхцөлдүүлдэг, харилцан шүтэлцээ бүхий хүн ам, газар нутаг, улс төр, нийгэм, эдийн засаг, түүх, соёл иргэншил зэрэг нь бүгд хамаарагддаг билээ. Үүний дотор, эдийн засгийн аюулгүй байдал нь эдийн засгийн хөгжлийн түвшин, потенциалиас шууд шалтгаална. Тухайн улсын эдийн засаг нь бие даасан, хараат бус байдал болон дэлхийн эдийн засгийн амьдралд үр ашигтай хоршин орших нь эдийн засгийн аюулгүй байдлын баталгаа юм. Монгол Улсын хувьд эдийн засгийн чадавхи, газар зүйн байрлал, хоёр их гүрний эдийн засгийн нөлөөнд дэлхийн эдийн засгийн бусад зонхилох тивүүдээс алс оршдог нь эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, дэлхийн эдийн засгийн амьдралд үр ашигтайгаар оролцохыг шийдвэрлэх нь нэлээд төвөгтэй байдлыг бий болгодог юм.

Монгол Улсын эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд нэгдэн нийлэх талаар тодорхой арга хэмжээнүүд хэрэгжүүлж байгаагийн дотор гадаадын шууд хөрөнгө оруулалт чухал байр эзлэх болов. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль нь гадаадын, ялангуяа эдийн засгийн хүчирхэг орнуудаас, түүний дотор АНУ-аас хөрөнгө оруулалтыг татах сонирхол сүүлийн жилүүдэд өсч байгаа бөгөөд уул уурхай, хөдөө аж ахуй гэх мэт салбарт түлхүү орох болов. Энэ нь АНУ-ын капитал, технологи, ноу хау, менежментийг ашиглан үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх, эдийн засгийн хөгжилд түлхэц өгч, улмаар эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд ихээхэн чухал үүрэгтэй билээ. АНУ-ын хөрөнгө оруулалт нь бодит эдийн засагт сайнаар нөлөөлж байгаа бөгөөд улмаар АНУ-ын хөрөнгө оруулалтыг илүү ихээр татах шаардлага тулгарч байгаа юм. АНУ нь манай улсын эдийн засагт

* М.Хурметхан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

гүйцэтгэж байгаа үүргийн хувьд томоохон хүчин бас ивээн тэтгэгч билээ. Ийнхүү Монголын эдийн засаг нь Америкийн эдийн засгаас нилээд хүчтэй хамааралтай болсон боловч санасан хэмжээ, түвшинд хараахан хүрээгүй юм.

Монгол Улс, АНУ-ын харилцаа хамтын ажиллагаанд худалдаа, эдийн засгийн харилцаа чухал ач холбогдолтой байдаг юм. Монгол Улс, АНУ-ын хооронд эдийн засгийн харилцаа нь хоёр улс 1987 онд дипломат харилцаа тогтоон, 1990-ээд онд Монгол Улсад өрнөсөн ардчилал, шинэчлэлийг АНУ анхнаас тууштай дэмжсэн тэр үеэс өргөн хүрээтэй эхэлж, хөгжиж байна. Өнгөрсөн харилцаанд Монгол Улсад зах зээлийн эдийн засгийн үндэс суурийг тавих, бэхжүүлэхэд шийдвэрлэх үүргийг АНУ дангаараа гүйцэтгэж ирсэн билээ. Монгол Улс, АНУ-ын харилцаа иж бүрэн түншлэлийн түвшинд хүрч батжин тогтох явцад худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа далайцтайгаар өргөжиж байна. Өнөөгийн байдлаар АНУ Монгол Улсын экспортын хоёрдахь томоохон түнш боллоо. АНУ-ын хөрөнгө оруулагчид Монголын талд хөрөнгө оруулан, ялангуяа, уул уурхайн салбарт хөрөнгө оруулах сонирхол өсөн нэмэгдэж байна. Монгол Улс АНУ-ын хөрөнгө оруулалтыг аль болохоор нэмэгдүүлэх, түүнийг эрчимжүүлэх, замаар өөрийн эдийн засгийн аюулгүй байдлаа хангахад анхаарлаа хандуулдаг юм. Иймээс, дэлхийн хүчирхэг эдийн засагтай АНУ-тай худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэх чиглэлээр Монгол Улс идэвхтэй бодлого, үйл ажиллагаа явуулж байгаа билээ.

Монгол Улсын ардчилал, зах зээлийн эдийн засгийн хөгжлийг АНУ тууштай дэмжиж, томоохон хандивлагч болов. АНУ-аас Монгол Улсад үзүүлэх дэмжлэг болон хэрэгжүүлэх буй хөтөлбөрийг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг /ОУХА/ удирдан хэрэгжүүлсээр ирлээ. АНУ-ын ОУХА нь 1991 онд анхны тусламжийн хөтөлбөрөө эхлүүлсэн 10 сая ам.доллартай тэнцэх яаралтай санхүүгийн тусламж үзүүлсэн тэр цагаас хойш 2007 оны эхний үе хүртэл 180 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлээд байгаа билээ.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын эрчим хүчний тулгамдсан асуудал, эрүүл мэнд, хүнсний яаралтай тусламж болон эдийн засаг, улс төрийн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан бөгөөд оруулсаар байгаа юм. АНУ-ын ОУХА нь 2004-2008 онд хамтран ажиллах стратегийг хэрэгжүүлэн төгсгөлийн шатандаа яваа юм. Энэхүү стратегийн үндсэн зорилго нь Монгол Улсад зах зээлийн тогтвортой эдийн засгийг хөгжүүлэхэд голчлон чиглэгдсэн байна. Тэрчлэн АНУ-ын ОУХА нь Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, гадаадын хөрөнгө оруулах сонирхлыг дээшлүүлэхэд туслахыг

зорьж байгаа юм. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалт түүний дотор АНУ-ын хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхой түвшинд хүртэл нэмэгдүүлэх нь манай эдийн засагт чанарын өсөлт бий болж гадаадын зээл, тусламжаас хараат байх явдал багасахад түлхэц болох билээ. Монгол Улс хөрөнгө оруулалтын болон бизнесийн орчинг сайжруулах, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахад анхаарал хандуулж байгаа боловч тодорхой бэрхшээлүүд оршсоор байна. Иймд, АНУ-Монгол Улсын хооронд хөрөнгө оруулалт, эдийн засгийн аюулгүй байдал зэрэг салбарт хамтын ажиллагааг улам өргөжүүлэхийн төлөө АНУ-ын ОУХА-тай цаашид ч хамтран ажиллах нь чухал хэвээр байна.

АНУ-аас хөгжлийн тусламж авч байгаагийн эцсийн зорилго бол Монгол Улс нь эдийн засгийн тогтвортой өсөлтөд хүрч, хүн амын орлогыг нэмэгдүүлснээр гадаадын зээл, тусламжаас бүрэн татгалзахад оршино. Дэлхийн хөгжсөн орнуудын туршлагаас харахад худалдаа болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр эдийн засгийн өсөлтийг хурдасган, эдийн засгийн бие даасан хөгжлийг хангаж байжээ.

АНУ нь Монгол Улсын гадаад худалдааны гол түнш нь билээ. АНУ-ын худалдаа, бизнесийн салбарынхан Монголд хөрөнгө оруулах, худалдаа хийх чиглэлд идэвхийлэн оролцож, манай эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулж ирсэн бөгөөд цаашид улам өсөх магадлалтай. АНУ нь Монголын зах зээл болж байгааг мөн тэмдэглэн хэлэх хэрэгтэй юм. Монгол Улс-АНУ-ын хоёр талын худалдааны эрх зүйн гурван баримт бичиг болох “Худалдааны харилцааны гэрээ” /1991/, “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих тухай хэлэлцээр” /1994/, “Худалдаа, хөрөнгө оруулалтыг хөгжүүлэх тухай хэлэлцээр” /2004/-ийн дагуу явагдаж байгаа юм. Өнөөгийн үед АНУ-тай Чөлөөт Худалдааны хэлэлцээр, давхар татвараас харилцан хамгаалах хэлэлцээр байгуулах нь амьдралаас дэвшигдэн гарч байгаа бөгөөд хоёр орны хооронд бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд чухал алхам болохоор байгаа билээ.

1999-2004 оны хооронд АНУ-д гаргаж байсан манай экспорт өсөх хандлагатай байсан бол АНУ-аас авч байсан импорт харилцан адилгүй хэлбэлзэлтэй байв. 2004 он хүртэл АНУ руу экспортлодог барааны ихэнх хэсгийг оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний квот дуусгавар болсоноор Монгол Улсаас энэ төрийн бүтээгдэхүүнийг экспортлох асуудал хүндрэл бэрхшээлтэй болсон билээ. Эдийн засгийн өсөлтөд худалдаа нэн чухал үүрэгтэйг бүрэн ойлгож АНУ-тай худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээр байгуулсан нь чухал алхам болов. Энэ хэлэлцээрийн дагуу жил бүр худалдааны байдлыг авч хэлэлцсэн хуралдаанууд удаа дараа болж, Монгол Улс-АНУ-ын худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэж байгаа юм. Энэ нь Монгол-Америкийн худалдаа, эдийн засгийн харилцаа шинэ

хэлбэр, агуулгаар баяжиж байгааг харуулж байна. Тухайлбал, 2006 онд Монгол-Америкийн “Бизнес форум”-ын анхны уулзалт болж, эдийн засгийн хамтын ажиллагааны талаар санал солилцоход үр дүнтэй механизм бүрэлдэн бий болов.

2006 оны эцсийн байдлаар Монгол Улс-АНУ-ын худалдааны нийт эргэлт 162 сая ам.доллар болж, үүнээс Монголын экспорт 118.8 сая ам.доллар /нийт экспортын 7.8%/, импорт 44 сая ам.доллар /нийт импорт 2.96%/ байна. Энэ үзүүлэлт 2005 онтой харьцуулахад 33 сая ам.доллараар буурчээ.¹ Монгол Улсаас АНУ-тай хийж байгаа гадаад худалдааны тэнцэл ашигтай байгаа хэдий ч гадаад худалдааны нийт эргэлт өмнөх онуудаас буурсан ажээ. Энэ нь оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний квот нь 2005 оны нэгдүгээр сарын 1-нээс хүчингүй болсонтой холбоотой билээ. АНУ-аас уул уурхайн хүнд тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, суудлын болон ачааны автомашин гэх мэт барааг импортлож байна.

Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулах, бизнес эрхлэх эрх зүйн таатай орчин бүрдсэн тэр үеэс АНУ-аас Монголд хөрөнгө оруулах болсон билээ. Монгол Улсад АНУ-ын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өсөхөд хөрөнгө оруулалтын эрх зүйн таатай орчин бүрдүүлэх талаархи хүчин чармайлт нөлөөлөв. 1990-2003 оны эцэс гэхэд 73 орноос 3042 компани нэг тэрбум гаруй ам.долларын хөрөнгө Монголд оруулахаар бүртгүүлсэн байлаа.² Энэ үед Монголд орсон гадаадын хөрөнгө оруулалтын дотор АНУ нь 11.4 хувийг эзэлж гуравдугаар байранд орж байв.³ Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээгээр АНУ нь 114.895 мянган ам.доллар байв. Энэ үед АНУ хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ 3 дугаар байранд орж, уул уурхай, газрын тос /194.3 сая ам.доллар/, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулалт /6,9 сая ам.доллар/, хөнгөн үйлдвэр /4 сая ам.доллар/, инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл /2,6 сая ам.доллар/ зэрэг салбаруудад⁴ түлхүү хөрөнгө оруулалт хийсэн байлаа. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 2005 оны тайланд дурдахдаа, АНУ-ын хөрөнгө оруулалтын хэмжээ уул уурхай, газрын тосны салбарт /21 сая ам.доллар/, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт /7 сая ам.доллар/, хөнгөн үйлдвэр /4,6 сая ам.доллар/, банк, санхүүгийн үйл ажиллагаанд /4,6 сая ам.доллар/, инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл /2,6 сая ам.доллар/ зэрэг салбаруудад түлхүү хөрөнгө оруулалт хийсэн мэдээлэл нийтлэгджээ.⁵

1990-2006 оны хооронд АНУ-аас Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалт жилд дундажаар 5,5 сая ам.доллар болж байгаа нь хангалттай бус гэдэг нь илэрхий болж байна. АНУ-аас дэлхийн бусад орнуудад оруулсан шууд хөрөнгө оруулалтын хэмжээ асар их билээ.

АНУ-ын шууд хөрөнгө оруулалтын их урсгалд татагдан орохын тулд Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчинг улам таатай болгох, АНУ-ын хөрөнгө оруулалтын эрх зүйн талаар үнэн бодиттой мэдээллээр хангах зэрэг цаг алдалгүй хийх ажил их байна.

АНУ-ын Засгийн газар Монгол дахь АНУ-ын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга замыг идэвхтэй хайж байна. Ер нь Монгол, Америкийн эдийн засгийн харилцаанд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт нэн чухал үүрэгтэй нь улам тодорхой болж байгаа билээ. Гэхдээ, Америкийн компаниуд Монгол дахь бизнес, хөрөнгө оруулалтын орчинг хүндрэлтэй гэж үзсээр байна. Хөрөнгө оруулагчдын санаа зовж буй асуудлын тоонд ил тод байдлыг нэмэгдүүлэх, оюуны өмчийг хамгаалах, гол гол салбаруудын хувьчлалыг үргэлжүүлэх, зах зээлд төр засгийн оролцоог багасгах зэрэг асуудал орж байна.

Гадаад хэргийн яамны 2006 оны үйл ажиллагааны тайланд дурдахдаа, “АНУ-аас манай улсад оруулж буй шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдээгүй /гадаадын нийт хөрөнгө оруулалтын 4 орчим хувийг эзэлж байна/ боловч америкийн бизнесийн салбарынхан манайхыг сонирхох хандлагатай⁶ хэмээн дурдсан байна.

Энд Вагнер Ази тоног төхөөрөмж, ГЛ монполимет Соко Тамсаг, Монгол ИНК зэрэг геологи, уул уурхайн газрын тосны эрэл хайгуул, судалгаа, олборлолтын салбарт, Эрдмийн компани катодын зэс үйлдвэрлэх, Монгол Амикаль, Форте Кашмер зэрэг компани ноолуур боловсруулах, Кока-Кола хүнсний салбарт, цахим холбоо, интернетийн үйлчилгээ үзүүлдэг Стифон, оёдолын үйлдвэрлэл салбарын Тинфар интернэшлн зэргийг дурдаж болох ажээ.

2007 оны эхээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байсан АНУ-ын хөрөнгө оруулалтай 110 орчим аж ахуйн нэгжийн 25 нь худалдаа, үйлчилгээний, 17 нь геологийн хайгуул, олборлолтын, 12 нь аялал жуулчлалын, 10 нь хөнгөн үйлдвэрийн, 5 нь банк санхүүгийн, 5 нь мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулах чиглэлээр ажиллаж, үлдсэн нь бусад салбарт ажиллаж байна.

1990-2007 оны хооронд АНУ-ын нийт 110 компани 88 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ. Эдгээрийн 53 нь Америкийн зуун хувийн хөрөнгө оруулалттай юм. АНУ-ын хөрөнгө оруулалтын хэмжээ жил жилд харилцан адилгүй байв. 1996 онд 10.25 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн, 2003 онд 115 сая ам.доллар, 2004 онд 128.519 ам доллар,⁷ 2006 онд 37 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ. 2007 оны есдүгээр сард Хойд Америк-Монголын зөвлөлийн хөрөнгө оруулагчдын чуулган Улаанбаатар хотноо болов. 10 дахь жилдээ болж буй энэ уулзалт зам тээвэр, хөрөнгийн зах зээл, уул уурхай, газрын тос, улс төрийн асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

АНУ-ын хөрөнгө оруулалтын хэмжээ бусад хөрөнгө оруулсан улсынхтай харьцуулахад харьцангуй бага, 2007 оны эхээр гадаадын шууд хөрөнгө оруулалтын 4 орчим хувийг л эзэлж байна. Америкийн бизнесийн салбарынхан, тухайлбал уул уурхайн компаниуд Монголыг сонирхож байна. Тухайлбал, дэлхийн хамгийн том нүүрсний компани болох АНУ-ын Пи боди Энержи нь Монголд хөрөнгө оруулах, бизнес эрхлэх боломжийг судалж, төлөөлөгчийн газрын нээжээ.

Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан Монгол, Америкийн Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөл 2005, 2006 онуудад хуралдаж, хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд учирч буй саад тотгорыг арилгах, хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлыг хэлэлцжээ. Худалдаа, татвар, оюуны өмч, технологи шилжүүлэх асуудлаар хэлэлцээ явуулах, хэлэлцээр байгуулах асуудал яригдан, бодит нөхцөл бүрдэж байгаа ажээ. Зөвлөл нь 2007 оны 3-р сард Улаанбаатар хотод хуралдан, худалдааг хөнгөвчлөх асуудлыг хэлэлцэв.

АНУ-тай Чөлөөт Худалдааны Хэлэлцээр /ЧХХ/ байгуулах нь Монгол Улсад эдийн засаг, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой билээ. Энэхүү хэлэлцээрийг байгуулсанаар АНУ руу гарах экспортын барааны татварыг үлэмж буруулах, улмаар тэлэх, худалдаанд учирч буй хориг саадыг хөнгөвчлөх, Монгол Улсад АНУ-ын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тогтвортой таатай орчин бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Худалдааны чөлөөт хэлэлцээр байгуулахад Монгол Улс өөрийн зүгээс ихээхэн ач холбогдол өгч байна.

Мөн АНУ, Монгол Улсын хооронд ЧХХ байгуулахыг АНУ-ын Сенат болон төлөөлөгчдийн танхмын тодорхой гишүүд дэмжиж тус тус тогтоолын төслийг Конгресст оруулсан билээ. АНУ-тай ЧХХ байгуулах бэлтгэл ажлууд хийгдэж байгааг дурдвал зохино. АНУ-ын Монгол Улсад хөрөнгө оруулсан болон оруулах томоохон компаниуд уг хэлэлцээрийг байгуулахыг дэмжиж байгаа билээ. ЧХХ байгуулах нь Монгол Улсын хөгжлийн хурдац, далайцыг нэмэгдүүлээд зогсохгүй, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах гол хүчин зүйл болно.

1991 оноос АНУ-ын Засгийн газар Монголд хөгжлийн тусламж үзүүлж ирлээ. Эдгээр төслүүд эдийн засаг, бизнесийн шинэчлэл, хөдөөгийн бизнесийг хөгжүүлэх, ядуурлыг буруулах, эрчим хүчний салбар, эдийн засгийн бодлогыг дэмжих, ардчиллыг бэхжүүлэх зэрэг чиглэлээр нийт 180 гаруй сая ам.долларын буцалтгүй тусламж олгожээ. 2007 оны есдүгээр сард АНУ Монгол Улсад дахин 6.595.435 ам.долларын буцалтгүй тусламж үзүүлэхээр болов. Ийм тусламж нь Монгол Улсын ирээдүйд чухал ач холбогдолтой ил тод сайн засаглал

болон худалдааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах эдийн засгийн зөв бодлогын асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэх юм.

АНУ-ын хөгжлийн тусламжийг цаашид манай орны иргэдийн боловсрол, шинжлэх ухааны салбарт түлхүү чиглүүлбэл эцэстээ Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын үйл хэрэгт жинтэй хувь нэмэр болох нь гарцаагүй юм.

АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш 2002 онд Хөгжиж байгаа орнуудад зориулж 5 тэрбум ам.доллар бүхий Мянганы Сорилтын Сан /МСС/ нээснээ дэлхий нийтэд зарласан юм. МСС түүний шалгуур үзүүлэлтийг Монгол Улс жил дараалан хангаж, МСС-гаас тусламж хүртэх орны тоонд багтаж ирлээ. Монгол Улсын боловсруулж МСС-д хүргэсэн боловсрол, эрүүл мэнд, дэд бүтцийн чиглэлийн төслүүд шалгарч хэрэгжиж эхлэх гэж байна. МСС-ийн шугамаар олгох буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр нь манай эдийн засгийн хөгжилд чухал түлхэц болохуйц билээ.

АНУ-ын Мянганы Сорилтын сангийн захирлуудын зөвлөл 2007 оны есдүгээр сарын 12-ний өдөр Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлыг бууруулах зорилгоор таван жилийн хугацаатай 285 сая ам.долларын компакт (Compact) гэрээг батлав. Монголын эдийн засгийн гол ачааг үүрдэг төмөр замын чадамжийг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэхэд 188.38 сая ам.доллар зарцуулах юм. 25.51 сая ам.доллар нь мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх, ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахуйц сургалтын тогтолцоо бүрдүүлэхэд зориулагдахаар болжээ.

17.03 сая ам.доллар нь эрүүлийг хамгаалах тогтолцоонд, ялангуяа гэмтэл согог, зүрх судас, хавдар, чихрийн шижин зэрэг өвчний эмчилгээ, оношлогооны тогтолцоог сайжруулах төсөлд зарцуулагдана.

23.06 сая ам.доллар нь Улаанбаатар болон бусад хотын гэр хорооллын иргэдэд, тэдний газраа эзэмших эрх, түүнийг бүртгүүлэх, амьдрах нөхцөлөө сайжруулах, өрхийн аж ахуй эрхлэх, хүнсний ногоо тариалах замаар ядуурлыг бууруулахад чиглэгдэнэ. Мөн 26.3 орчим сая ам.доллар нь дээрх төслүүдийн удирдлага, захиргааны зардалд зарцуулана.

Төмөр замын болон эрүүл мэндийн төслүүд нь улсын нийт эдийн засгийг хамарсан өргөн хүрээтэй байхаас мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн ба гэр хорооллын төслүүдийн үр шимийг 1,5 сая гаруй хүн шууд хүртэх сайхан боломж нээгдэж байгаа юм.

МСС-гаас тусламж авах Ерөнхий гэрээ байгуулан, уг сангийн тусламжийг авч ашиглах болсон нь Монгол Улсын эдийн засаг дахь АНУ-ын туслалцаа чанарын шинэ шатанд гарч буй хэрэг юм. Эдгээр төсөл нь Засгийн газраас байгалийн үндэсний хөгжлийн тэргүүлэх

чиглэлд уялдсан учир Монгол Улсын эдийн засгийн хөгжилд жинтэй хувь нэмэр болж, улмаар Монголын эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлаа хангахад томоохон хувь нэмэр болох юм.

АНУ нь МСС-гийн хөтөлбөрийн хүрээнд 188.38 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг төмөр замын салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Энэ нь зүтгүүр, вагон, мэдээлэл, дохиоллын хэрэгсэлийг АНУ-ын буцалтгүй тусламжаар авахаар төлөвлөж байгаа юм. АНУ, Монгол Улсын Засгийн газрын хооронд гэрээнд гарын үсэг зурагдсанаар 2007 оны төгсгөл 2008 оны эхэнд МСС-ийн хөтөлбөр эхэлж, төмөр замын тоног төхөөрөмж Монголд орж ирэх ажээ. Үүнийг Монголын төмөр зам, төмөр замаар үйлчлүүлэх сонирхолтой томоохон ачаа илгээгчид, томоохон уурхай, цахилгаан станц сонирхож байна. Мөн Ази, Европыг холбосон цаг хугацааны хувьд хамгийн богино, орон зайн хувьд хамгийн дөт зам билээ. Энд оруулсан хөрөнгө харьцангуй бага хугацаанд үр ашгаа өгөх нь тодорхой юм.

АНУ-ын хөрөнгө оруулалтын нөхцлийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг татах олон төрлийн шийдвэр гаргаж, арга хэмжээ авч байгаа боловч, хөрөнгө оруулалт хийж буй талынхаа сэтгэлд хүрэхгүй, хөрөнгө оруулалтын үр ашиг харагдахгүй байгааг хэлэх хэрэгтэй юм. Энэ нь ялангуяа, уул уурхайн салбарт дахь хөрөнгө оруулалтын орчин зарим талаар ойлгомжгүй байгаатай холбоотой болов уу. Мөн Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчинг гадаадад сурталчлах, явдал хангалтгүй, дотоод байдал тогтворгүй, хууль дүрмийг ойр ойр өөрчлөх, татварын тогтолцоо, хүнд суртал, авилга гэх мэт таагүй зүйл хөрөнгө оруулагчдыг үргээж байгаа зэргийг арилгах нь чухал билээ.

АНУ нь гадаадад хөрөнгө оруулалт хийх талаар баялаг туршлагатай юм. Дэлхийн олон орны эрчимтэй хөгжил нь АНУ-ын хөрөнгө оруулалт тусламжтай шууд холбоотой билээ. Тиймээс улс орныхоо эдийн засгийн хөгжил, аюулгүй байдлыг хангах асуудлыг АНУ-ын хөрөнгө оруулалт, тусламжгүйгээр төсөөлөх аргагүй юм. АНУ-ын хөрөнгө оруулалтыг даган дэлхийд шинжлэх ухаанаар тэргүүлж буй АНУ-ын шинэ өндөр технологи, өндөр мэдлэг орж ирнэ. Энэ нь ирээдүйд Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг бататган хангах баттай үндсийг бүрдүүлнэ.

Энэхүү эдийн засгийн хамтын ажиллагаа нь ойрын, дундын, алс хэтийн зорилттой байх нь ойлгомжтой. Ойрын зорилтонд хоёр орны худалдаа, эдийн засгийн орчинг улам таатай болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, давхар татвараас зайлсхийх хэлэлцээр, ЧХХ байгуулах АНУ-ын хөнгөлөлтийн ерөнхий системд хамрагдаж буй барааны нэр төрлийг олшруулах, Монголын экспортын барааны

хэмжээг нэмэгдүүлэх, АНУ-ын хөрөнгө оруулалтыг татахуйц тааламжтай орчинг бүрдүүлэх зэрэг зорилтууд орж байгаа юм.

Дунд үеийн зорилтод хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааг олон тал, бүс нутагт АПЕК, ДХБ-ын хүрээнд зохицуулан эрчимжүүлэх гм. байх ажээ. Алс хэтийн зорилтод Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтад АНУ-ын хувийн жинг эрс нэмэгдүүлэн дор хаяж 1/3-д хүргэх нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах чухал ач холбогдолтой хүчин зүйл болно. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нь олон хүчин зүйлүүдийн нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжих бөгөөд дэлхийн эдийн засгийн амьдралд үр ашигтай оролцон, эдийн засгийн хүчирхэг чадавхи бүхий АНУ-ын эдийн засагтай нягт хамтран ажиллах нь улам чухал болж байна. АНУ-ын хөрөнгө оруулалтыг хүчтэй татаж, хамтын үйлдвэр байгуулах замаар үндэстэн дамнасан өмчийн хэмжээг нэмэгдүүлэх нь эдийн засгийн гадаад хүчин зүйл бөгөөд эдийн засгийн аюулгүй байдлыг бататгах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх чухал механизм байх юм.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Монгол АНУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын хандлага /ҮХЯ-ны ХЭЗХАТ дарга В.Энхболдын илтгэл 2007 оны 1-р сарын 24 т.1
2. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тойм. 2002, 2003 тэргүүн дэвтэр т.3
3. Мөн тэнд т.5
4. Мөн тэнд т.6
5. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тойм. 2005. Гутгаар дэвтэр т.10
6. Гадаад хэргийн яамны 2006 оны үйл ажиллагааны тайлан. №2/178/2007 оны 1-р сар 2007 т.26
7. Гадаадын шууд хөрөнгө оруулалт тойм 2004. Дэд дэвтэр. т.9